



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Дадлагажуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1, 6.2.10, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.3.2, 4.3.3, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны сургалт, дадлагын журмын 7.5(а), Аэродромын нислэгийн мэдээллийн ажилтны зэрэглэл горилогчийг ажлын байранд дадлагажуулах хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Завхан аймаг дахь “Доной” нисэх буудлын харуул Бямбаагийн Лхам-Осор, Баян-Өлгий аймаг дахь “Өлгий” нисэх буудлын бичиг хэргийн ажилтан Муратын Ерлан нарыг 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөс Аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл эзэмшигчийн ажлын байранд 100 цаг дадлагажуулсугай.

2. Батлагдсан хөтөлбөрийн дагуу дадлагажуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг багш нислэгийн удирдагч (Ч.Лхагвасүрэн, Г.Ганхуяг) нарт, дадлагажигчийг дадлагажих хугацаанд ажлын зохицуулалт хийж ажиллахыг Завхан аймгийн “Доной” нисэх буудал (Д.Алтан-Уул)-д, Баян-Өлгий аймгийн “Өлгий” нисэх буудал (К.Ержан)-д, хяналт тавьж ажиллахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба (П.Пүрэвсүх)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Дадлагажуулахтай холбогдон гарах зардлыг холбогдох журмын дагуу зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар /Б.Батхишиг/-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0598